

БАТЛАВ.

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН

Н.ЭНХБОЛД

## **АХМАД НАСТНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

### **Нэг.Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага**

#### **1.1.Хууль зүйн үндэслэл**

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого”-ын 2.6.16-т “Хүн амын бүлгүүд, тухайлбал ...ахмад настан хагас цагаар, гэртээ, зайнаас ажиллах уян хатан зохицуулалт бий болгоно.”, 3.1.13-т “Ахмад настанд урт хугацааны тусламж үйлчилгээ үзүүлэх хөгжлийн төвүүдийг байгуулна.”, 3.1.18-т “Ахмад настанд ... үзүүлэх урт хугацааны тусламж үйлчилгээний нэгдсэн, цогц тогтолцоог бүрдүүлнэ.” гэж тус тус заасан.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 2.3.4-т “...ахмад настанд ээлтэй, хүртээмжтэй орчин нөхцөлийг бүрдүүлж, хөдөлмөр эрхлэх боломжоор хангана”, 4.3.3-т “..ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хангах түр хамгаалах байрыг байгуулж, хуульд заасны дагуу мэдээллээр хангана.” гэж заасан.

Түүнчлэн Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэлийг хэлэлцсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн 35 дугаар тогтоолын 3 дугаар зүйлд “Ахмад настны эрхийн хэрэгжилтийн талаар: а/ахмад настны тусламж үйлчилгээний нэгдсэн, цогц тогтолцоог бүрдүүлэх зорилтыг эрчимжүүлэх, насжилтын үеийн өвчний эрсдэлийг нэмэгдүүлдэг хүчин зүйлүүдийг бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх; б/ахмад настныг ажлын байраар хангаж байгаа ажил олгогч, аж ахуйн нэгжүүдийг татварын болон бусад бодлогоор дэмжих; в/ахмадын асрамж, хамгаалал, сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах, чөлөөт цагаа өнгөрүүлэх орчин нөхцөлийг бий болгох асуудлаар цогц бодлого боловсруулж, хэрэгжүүлэх.” асуудлыг тусгасан.

#### **1.2.Практик шаардлага**

Ахмад настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах дараах практик хэрэгцээ, шаардлага тулгараад байна.

Дэлхийн хүн амд 65 ба түүнээс дээш насны ахмадууд 2022 онд 10 хувийг эзэлж байгаа ба 2030 онд 12 хувь буюу 994 сая, 2050 онд 16 хувь буюу 1.6 тэрбум болж өснө<sup>1</sup>. Монгол Улсын хувьд ч мөн адил хүн амын насны бүтэц өөрчлөгдөж, хүн амын тоо сүүлийн 10 жилд 16.1 хувиар өссөн бол мөн хугацаанд ахмад настны тоо 21.9 хувиар буюу илүү хурдацтай өссөн байна. 2000 онд 60 ба түүнээс дээш насны иргэд нийт хүн амын 5.4 хувь, 2010 байдлаар 5.8 хувь, 2021 оны байдлаар 9.7 хувь байгаа бол 2030 онд 11.9 хувь, 2050 он гэхэд 5 хүн тутмын нэг нь 60 ба түүнээс дээш настай болох магадлалтайг Үндэсний статистикийн хорооноос тооцоолсон. 2022

<sup>1</sup> <https://www.visualcapitalist.com/cp/charted-the-worlds-aging-population-1950-to-2100/>

оны байдлаар Монгол Улсад нийт хүн амын 10.1 хувь буюу 344.6 мянган ахмад настан байна.

Хүн ам зүйн өөрчлөлтийн улмаас нийт хүн амын дунд ахмад настнуудын эзлэх хувь хурдацтай өсөж байгаатай уялдуулан насжилтад бэлтгэх, ахмад настанд үзүүлэх урт хугацааны цогц тусламж үйлчилгээний болон ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлогыг сайжруулах зорилгоор Ахмад настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулав.

**Ахмад настны тусламж үйлчилгээний нэгдсэн, цогц тогтолцоог бүрдүүлэх, урт хугацааны тусламж үйлчилгээг хөгжүүлэх бодлогын талаар:**

Дэлхийн эрүүл мэндийн байгууллага (ДЭМБ)-аас “Номхон Далайн Баруун Бүсийн Эрүүл насжилтын үйл ажиллагааны төлөвлөгөө”-д “Ахмад настны эрүүл мэнд, нийгмийн халамжийн хэрэгцээг цогц байдлаар, урт хугацааны туршид тасралтгүй тусламж үйлчилгээгээр хангах” заалтыг хэрэгжүүлэхэд “Ахмад настны цогц тусламж, үйлчилгээ”-г өөрийн орны нөхцөл байдалтай уялдуулан эрх зүйн зохицуулалт хийхийг зөвлөсөн байна<sup>2</sup>.

2017 онд шинэчилсэн найруулгаар батлагдсан Ахмад настны тухай хуульд ахмад настанд зөвлөгөө өгөх, өдрийн үйлчилгээ, явуулын үйлчилгээ болон өдрөөр эмчлэх, асран сувилах үйлчилгээ зэрэг шинэ төрлийн үйлчилгээг бий болгож, иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэхээр тусгасан ч энэ шинэ үйлчилгээний хэрэгжилт тун хангалтгүй байна. Энэ төрлийн үйлчилгээнд тухайлбал 2022 оны байдлаар 2300 хүнд 0.6 тэрбум төгрөг зарцуулж, нийт ахмад настны нэг хүрэхгүй хувийг хамруулж байгаа нь Монгол Улсад ахмад настныг дэмжих, хөгжүүлэх, нийгмийн амьдралд оролцуулах зэрэг үйлчилгээ байхгүйтэй адил байна гэсэн үг юм.

Ахмад настны тухай хуулийн ихэнх заалтын хэрэгжилтийг хангах чиг үүргийг орон нутгийн байгууллагад өгсөн боловч нэгдсэн арга зүй, удирдлага, зохион байгуулалтаар хангах байгууллага болон арга механизм нь тодорхойгүй, орон нутгийн төсөвт хангалттай хөрөнгө тусгагдаагүй зэрэг шалтгаантай байна. Түүнчлэн Ахмад настны тухай хуулийн дагуу үзүүлэх үйлчилгээ, дэмжлэг туслалцаа нь ахмадуудын тодорхой зорилтот бүлэгт бус, нийт ахмадуудын эрэлт хэрэгцээнд үндэслэх шаардлагатай.

Дэлхийн улс, орнууд хүн ам зүйн өөрчлөлт, насжилт, ахмад настны тооны хурдацтай өсөлтийг тооцон ахмад настны урт хугацааны асаргаа үйлчилгээ, дэмжлэг, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн амьдралын оролцоо, дэмжлэгийн бодлого, шийдвэрээ эргэн харж сайжруулан, санхүү төсвөө ч дорвитой нэмэгдүүлэхэд анхаардаг болсон.

Одоогоор манайд ахмад настанд зөвхөн протез, ортопедийн хөнгөлөлт үзүүлэх, амралт рашаан сувиллын хөнгөлөлтийг жилд нэг удаа үзүүлэхээс өөр тэдэнд зориулсан байнгын тогтмол үзүүлдэг төрөл бүрийн сэргээн засалтын болон хөгжил, хамгааллын үйлчилгээ дутагдалтай байна.

Иймд эрүүл мэндийн байгууллагын эмч, нийгмийн ажилтан ахмад настны бие махбод, сэтгэцийн эрүүл мэнд, нийгмийн асуудлын нөхцөл байдлыг цогцоор үнэлэн,

---

<sup>2</sup> <https://www.who.int/publications/i/item/WHO-FWC-ALC-19.1>

ахмад настны хам шинж, байдлыг илрүүлж, тулгамдсан асуудлыг эрэмбэлэн, тусламж үйлчилгээний төлөвлөгөө гарган үйлчилгээнд хамруулан, эргэн хянах үйл ажиллагааг хэрэгжүүлэх шаардлагатай байна. Гэхдээ ахмад настанд аль болох хүндрэл чирэгдэл үүсгэхгүй байхад анхаарч, цахим систем нэвтрүүлэх, хэвтрийн өвчтэй ахмад настны хувьд явуулын үйлчилгээ үзүүлэх зэргээр хэрэгжилтийг уян хатан зохицуулах шаардлагатай.

Одоо мөрдөж байгаа Ахмад настны тухай хуульд засаг захиргааны нэгжүүдэд зөвхөн Ахмадын өргөө ажиллуулна гэж заасан нь өрөөсгөл юм. Үйлчилгээний хувьд ахмадад үзүүлэх үйлчилгээний төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу өөрт нь болон гэр бүл, асран хамгаалагчдад зөвлөгөө өгч, эрүүл насжилтыг дэмжих үйлчилгээ үзүүлдэг төв, ахмадын төв, сэргээн засах төвд хамруулах, гэрийн үйлчилгээ, өдрийн үйлчилгээ, амралт, сувиллын газар зэрэг газруудад холбон зуучлах шаардлагатай.

Аймаг дүүргийн Хөдөлмөр, халамжийн халамжийн үйлчилгээний газруудад 1-2 ахмадын сувилал төрийн өмчид байдаг. Сүүлийн жилүүдэд хувийн амралт сувиллууд олон болсон, нөгөө талаар нэг сувилуулагчийн зардал 7-10 хоногт 200.0 орчим мянган төгрөг байгаа нь ажиллагсдын цалин, сувилуулагчийн хоол бусад зардалд хүрэлцэхгүй байгаа тухай тайлбарлаж зарим аймаг нь үйл ажиллагаагаа зогсоож зарим аймаг Засаг даргын тамгын газартаа шилжүүлсэн байдалтай байна. Иймд энэ сувиллын газруудыг шинэчлэн зохион байгуулж эрүүл насжилтыг дэмжих үйлчилгээ үзүүлдэг төв болгон зохион байгуулах боломжтой. Мөн ахмадын өргөө болон соёлын ордон, олон нийтийн төвүүд зэрэг барилга байгууламжид төрөл бүрийн үйлчилгээг иргэн, аж ахуйн нэгж, ТББ-аар гэрээлэн гүйцэтгүүлэх шаардлагатай байна.

Тухайлбал, эрүүл насжилтыг дэмжих үйлчилгээ үзүүлэх төвд ахмад настанд зориулсан сургалт, өдрийн үйлчилгээ, зөвлөгөө өгөх гэх мэт төрөл бүрийн үйл ажиллагааг хувийн хэвшил төрийн бус байгууллагатай гэрээлэх, мөн туршлагатай багш нартай цагийн хөлсийг тооцож гэрээлэх зэргээр үйлчилгээ үзүүлж, улмаар ахмад настны хэрэгцээнд нийцсэн үйлчилгээг хөгжүүлэх бүрэн боломжтой. Зарим төсвийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас ахмад мэргэжилтний зөвлөгөө өгөх арга хэмжээний хүрээнд санхүүжүүлж болно.

Иймд ахмад настны цогц тусламж үйлчилгээний тогтолцоог бүрдүүлэх, хөгжүүлэхийн тулд санхүүжилтийг тодорхой зааж, эрүүл мэндийн болон нийгмийн хамгааллын байгууллагын, орон нутгийн зэрэг хамтарсан санхүүжилтийн эх үүсвэртэй болгох шаардлагатай байна.

Протез, ортопедийн болон тусгай хэрэгслийн тохируулга хийх талаар эмч, мэргэжилтэн зөвлөгөө өгч, эм, эмнэлгийн хэрэгслээр үйлчлүүлэх хөнгөлөлтөд хамруулах ажлыг эмийн хөнгөлөлт олгодогтой ижилхэн ахмад настан зах зээлээс хүссэн газраар үйлчлүүлэх боломжтой байдлаар зохицуулах, энэ ажлыг эрүүл мэндийн байгууллагатай хамтран зохион байгуулах шаардлагатай.

Ахмад настны сэргээн засалтын үйлчилгээ, ахмад настны эрүүл мэндийг дэмжих сургалт, үйлчилгээ, өдрөөр эмчлэх, асран сувилах үйлчилгээ; ахмад настны дасгал, хөдөлгөөн, эрүүл мэнд, нийгмийн оролцоог дэмжих үйлчилгээ, протез, ортопедийн болон тусгай хэрэгслийн хөнгөлөлт, рашаан, сувиллын хөнгөлөлт зэрэг үйлчилгээ нь ахмад настны эрүүл мэндтэй шууд холбоотой асуудлууд юм. Иймд хуулийн төсөлд ахмад настны цогц үнэлгээ, ахмад настанд үзүүлэх цогц тусламж,

үйлчилгээ, ахмад настны асаргааны хувилбарт үйлчилгээ зэрэг урт хугацааны асаргаа үйлчилгээний асуудлыг нэмж тусгаж, эрүүл мэндийн байгууллагын оролцоо, санхүүжилтийг тодорхой зааж, хуулийн хэрэгжилтийг хангахад эрүүл мэндийн болон нийгмийн хамгааллын байгууллагуудын хамтын оролцоог тусгана.

Мөн Нийгмийн халамжийн тухай хуулийн дагуу хүнд хэлбэрийн хэвтрийн өвчтэй ахмад настнуудыг гэр бүлдээ асарч байгаа иргэнд сар бүр тэтгэмж өгч байгаа нь хэвтрийн өвчтэй ахмад настантай өрхийг эдийн засгийн хүндрэлээс сэргийлэхэд дэмжлэг үзүүлж нөгөө талаар асаргаа үйлчилгээг гэрийн нөхцөлд хийж байгаа сайн талтай. Гэхдээ нөгөө талаар асарч байгаа иргэд нь ахмад настан голдуу байгаа нь нэг ахмад настан нөгөө ахмад настнаа асарч ядрах, сульдах, гэр бүлийн гишүүдэд асаргаа үйлчилгээний талаар сургалт байхгүйгээс мэдлэг дутмаг байна.

Төрөлжсөн асрамжийн үйлчилгээний газрын эрэлт хэрэгцээ байгаа ч асрамжийн газрын тоо цөөн хүрэлцээ муутай байна. Улсын хэмжээнд 300 хүрэхгүй ахмад настан төрөлжсөн асрамжийн газарт асруулж байна. Хувийн 4 асрамжийн газар байдаг ч төрөөс үзүүлдэг дэмжлэг маш бага тул үйл ажиллагаагаа явуулахад хүндрэлтэй, хувийн асрамжийн газар үйл ажиллагаа явуулахад төрөөс олгох санхүүжилт маш бага байна.

Иймд ахмад настны цогц тусламж үйлчилгээний тогтолцоог бүрдүүлэх, санхүүжилтийг тодорхой болгох, урт хугацааны тусламж үйлчилгээг хөгжүүлэх шаардлагын үүднээс дээрх асуудлуудыг холбогдох хуульд нэмэх, хуулийн зарим заалтыг өөрчлөх шаардлагатай байна.

#### **Ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх талаар:**

Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод зорилтот бүлгийн иргэдийг дэмжсэн, бүтээмжтэй ажил, хөдөлмөр эрхлүүлэх, хүн амын бүлэг бүрийн онцлогт нийцсэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих талаар баримтлах бодлого, хөтөлбөр хэрэгжүүлж, хүн амын бүлгүүд, тухайлбал: эмэгтэйчүүд, оюутан, залуучууд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахмад настан хагас цагаар, гэртээ, зайнаас ажиллах уян хатан зохицуулалт бий болгох, ахмад настанд урт хугацааны тусламж, үйлчилгээ үзүүлэх хөгжлийн төвүүдийг байгуулах гэж тусгасан байна.

Ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээ нь хязгаарлагдмал, хамрагдалт бага байна. Тухайлбал, ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээнд 2022 онд ахмад настны зөвлөх үйлчилгээнд 848 ахмад хамрагдаж, 707.4 сая төгрөг, эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээнд 1,056 ахмад хамрагдаж 4.4 тэрбум төгрөг, хүүхэд хамгаалагч үйлчилгээнд 346 ахмад хамрагдаж, 303.1 мянган төгрөг буюу нийт 5.4 тэрбум төгрөг зарцуулжээ. Энэ зардлын 4.4 тэрбум нь эргэн төлөгдөх нөхцөлтэй зээл байна. Хөтөлбөрт хамрагдсан ахмад настны тоо 2022 онд 2230 ахмад настан байгаа нь нийт ахмад настантай харьцуулахад маш бага хувийг эзэлж байна.

Хүн амын дунд ахмад настны тоо нэмэгдэж, ахмад настнууд эрт тэтгэвэрт гарч, хүн амын дундаж наслалт тогтмол нэмэгдэж улмаар хөдөлмөрийн насны хүн амд ноогдох ахмад настнуудын тоо нэмэгдэж, 2010 онд 10 ажилтан тутам нэг ахмад настан байсан бол, 2040 он гэхэд 4 ажилтан тутам 1 ахмад настан ногдохоор байна. Өөрөөр хэлбэл хүн ам насжихын хирээр залуу ажилчдын эзлэх хувь буурах тул мэдлэг чадвартай, ажил амьдралын туршлагатай ахмад ажилчдын хөдөлмөр

эрхлэлтийг зохистой хэлбэрээр дэмжих шаардлага тулгарч байна. Иймд ахмад настны тогтвортой орлогын эх үүсвэрийг хангах зорилгоор ахмад настнуудыг үргэлжлүүлэн хөдөлмөр эрхлүүлэхийг дэмжих, эдийн засгийн идэвхийг нь хадгалах, ахмад настнууд өөрийн чадавхыг амьдралынхаа туршид бүрэн дүүрэн ашиглах, тэдний мэргэжил, туршлага, ур чадварт түшиглэж залуу үеийг сургах, нөгөө талаар ахмад настан бүх нийтийн үйл хэрэгт идэвхтэй оролцох оролцоог дэмжин ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих олон талт бодлогыг батлан хэрэгжүүлэх шаардлагатайг харуулж байна.

Ахмад настны хөдөлмөрлөх эрх зүйн орчныг нарийвчлан тодорхойлоогүйн улмаас насаар ялгаварлан гадуурхагдах, өөрөө хүсээгүй ч эрт тэтгэвэрт гаргах, ахмад настны цалин хөлсийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр тооцох зэрэг зохисгүй үйлдлүүд гарч байна.

Иймд ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор ахмад настан өөрөө нийгмийн даатгалын шимтгэл төлөх шаардлагагүй гэж үзвэл тухайн ахмад настныг авч ажиллуулж байгаа байгууллага тэтгэврийн даатгалын шимтгэл 8.5 хувийг төлөхгүй байх, 50 ба түүнээс дээш ажиллагсадтай аж ахуйн нэгжийн 2-оос доошгүй хувьд ахмад настан авч ажиллуулах, мод, хүнсний ногоо тарих зэрэг байгаль орчны болон хүнс үйлдвэрлэл, хөдөө аж ахуйн салбарт ахмад настныг ажиллахыг дэмжиж хөнгөлөлттэй зээл олгох, цалин хөлсийг зах зээлийн ханшаар ажилласан хугацаанд тооцон цагаар, өдрөөр гэх мэт уян хатан хэлбэрээр олгох, ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр арга хэмжээг өргөжүүлэх зэрэг эрх зүйн зохицуулалтыг тусгана.

#### **Ахмад настны эсрэг хүчирхийллийн талаар:**

Ахмад настны тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай, Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, Гамшгаас хамгаалах тухай хууль, Нийгмийн халамжийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжоор ахмад настныг ялгаварлан гадуурхах, дарамт хүчирхийллээс хамгаалахад чиглэсэн чухал зохицуулалтыг тусгасан байна.

Сүүлийн жилүүдэд гэр бүлийн хүчирхийллийн дуудлагад ахмад настны эсрэг хүчирхийлэл нэмэгдэж байна. 2020 оноос 2022 оны байдлаар Хүчирхийллийн эсрэг үндэсний төвд хандсан ахмад настны эсрэг үйлдэгдэж буй хүчирхийллийг хэлбэрээр нь авч үзвэл эдийн засгийн хүчирхийлэл 36 хувийг эзэлж байна.

Ахмад настан нь аливаа хүчирхийлэл, дарамтаас ангид байх Ахмад настны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.6 дахь заалтад "ахмад настны эсрэг хүчирхийлэл"-ийн талаар тусгажээ. Гэвч сүүлийн үед ахмад настанд тохиолдож байгаа эдийн засгийн хүчирхийлэл буюу тэтгэвэр, тэтгэмжийг нь зөвшөөрөлгүй зарцуулах, барьцаалж зээл авах, өмч хөрөнгийг нь дур мэдэн зарцуулах, ашиглах, үл хөдлөх хөрөнгийг нь өөрийн нэр дээр авах, байрнаас нь хөөх, хөрөнгөнөөс болж үр хүүхдүүд нь маргаж, сэтгэл санааг нь зовоох зэрэг асуудлын зохицуулалт сул байна. Мөн ахмад настан хүчирхийлэлд өртсөн тохиолдолд үзүүлэх эрүүгийн болон зөрчлийн хуулийн шийтгэлийг тодорхой болгох шаардлагатай байна.

### **Оршуулгын зардал, ганц бие ахмад настны өв залгамжлалын талаар:**

Оршуулгын үйлчилгээний зардал хэт өндөр байгаа, ганц бие ахмад настан болон орон гэргүй тэнэмэл амьдралтай иргэн нас барахад оршуулгын үйл ажиллагааг зохион байгуулах, төрөөс энэ үйл ажиллагааг хариуцах эзэн болон, санхүүжилт тодорхойгүй тухай гомдол, санал төрийн байгууллагуудад ирдэг ч энэ талаар хуулийн зохицуулалт байхгүй байна.

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 35.2.3 дахь заалтад оршуулгын үйл ажиллагааны журмыг Иргэдийн төлөөлөгчдийн хурал батлахаар заажээ. Энэ дагуу тухайлбал Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2024 оны 8 дугаар тогтоолоор “Оршуулгын үйл ажиллагаа эрхлэх, зохион байгуулах, зөвшөөрөлтэй оршуулгын газар болон зөвшөөрөлгүй газар оршуулсан шарилыг шилжүүлэх журам” баталжээ. Уг журмын 11.1 дэх хэсэгт “Оршуулгын үйл ажиллагааны үнэ тарифыг оршуулгын үйл ажиллагаа эрхлэгч өөрөө тогтоох бөгөөд нас барагчийг төлөөлөх этгээд үйлчилгээний зардлыг хариуцна.” гэж заажээ. Ингэснээр цөөн хэдэн оршуулгын үйл ажиллагаа эрхэлдэг гадаад, дотоодын компани өндөр үнээр оршуулгын үйл ажиллагааг явуулах эрх зүйн үндэслэлийг олгож өгсөн нь иргэд, ахмад настнуудыг бухимдуулж “нас бараад оршуулгын газартаа 5-6 сая төгрөг төлж хүүхдүүдээ өрөнд оруулж байна” гэсэн гомдол ихээр гаргаж байна. Нөгөө талаар дээрх журамд “11.3.Энэ журмыг зөрчиж, зөвшөөрөлгүй газар нас барагчийг оршуулсан бол шарил (цогцос)-ыг шилжүүлэн оршуулах үйл ажиллагааны зардлыг нас барагчийг төлөөлөх этгээд хариуцна.” гэжээ. Иймд Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.2.3 дахь заалтад оршуулгын үйл ажиллагааны жишиг үнийг тогтоох зохицуулалт нэмж тусгана.

Мөн ганц бие ахмад настан нас барахад эд хөрөнгө, банкны хадгаламж зэрэг нь Иргэний хуулийн дагуу төрийн өмчлөлд шилжинэ гэж заасан ч төрийн өмчлөлд шилжсэн тохиолдолд хөрөнгийг бүртгэх, зарцуулах эрх зүйн зохицуулалт сул байгааг харгалзан Иргэдийн төлөөлөгчдийн хурал энэ талаар зохицуулалтын журам гаргахаар Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт оруулах тухай төсөлд тусгана.

### **Хоёр. Ахмад настны тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ**

Ахмад настны тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн зорилго нь Ахмад настны тухай хуулийн давхардал, хийдлийг арилгаж, ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, ахмад настныг ажлын байраар хангаж байгаа ажил олгогч, аж ахуйн нэгжүүд, ахмадын байгууллагуудыг дэмжих, ахмадын асрамж, хамгаалал, урт хугацааны тусламж үйлчилгээний санхүүжилт, ахмад настанд үзүүлэх үйлчилгээг удирдлага зохион байгуулалтаар хангах зохицуулалтыг сайжруулна.

Хуулийн төсөл нь зургаан зүйлтэй. Нэгдүгээр зүйлийн нэг дэх хэсэгт ахмад настанд үзүүлэх ахмад настны цогц үнэлгээ, ахмад настанд үзүүлэх цогц тусламж, үйлчилгээ, ахмад настны асаргааны хувилбарт үйлчилгээ, сэргээн засах үйлчилгээ, ахмад настны эрүүл мэндийг дэмжих сургалт, үйлчилгээ, ахмад настанд үзүүлэх цогц тусламж, үйлчилгээний мэргэжлийн удирдлага зэрэг нэр томъёог шинээр нэмнэ.

Ахмад настны цогц үнэлгээ, ахмад настны цогц тусламж үйлчилгээний заавар, үйлчилгээний үнэ тариф болон үйлчилгээ үзүүлэх журмыг эрүүл мэндийн

болон ахмад настны асуудал хариуцсан Засгийн газрын гишүүд хамтран батлах, санхүүжилтийг эрүүл мэндийн даатгалын сан, нийгмийн халамжийн сан, орон нутгийн төсвөөс болон ахмад настны оролцоотойгоор санхүүжүүлэхээр тусгана.

Төрийн болон орон нутгийн өмчит барилга, байгууламжид ахмадын өргөө, ахмадын төв, сэргээн засах төв, эрүүл насжилтыг дэмжих төв, дасгалын клуб, олон нийтийн төв ажиллуулж байгаа үйлчилгээг үзүүлж байгаа бол тухайн барилга, байгууламжийн ус, дулаан, цахилгаан зэрэг урсгал зардлыг үйлчилгээ үзүүлж байгаа хуулийн этгээдтэй байгуулсан гэрээний үндсэн дээр хэсэгчлэн болон бүрэн орон нутгийн төсвөөс хариуцан санхүүжүүлэхээр тусгана.

Ахмад настны асрамжийн үйлчилгээний нэр төрлийг нарийвчлан тусгаж, үйлчилгээг иргэн, аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагаар дамжуулан төлбөртэй, бага төлбөртэй, төлбөргүй зэрэг олон хэлбэрээр үзүүлэх санхүүжилт, үйлчилгээний удирдлага зохион байгуулалтын талаар Нийгмийн халамжийн тухай хуульд нэмж тусгана. Байнгын асаргаа шаардлагатай ахмад настныг асарч байгаа иргэний ачааллыг үнэлэн, дэмжлэг үзүүлэх асуудлыг тусгана.

Ахмад настны эсрэг эдийн засгийн хүчирхийллийн талаар нэмж, холбогдох хуулиудад хариуцлагын асуудлыг тодорхой тусгана. Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай ахмад настанд жилд нэг удаа түлш худалдан авах, орон сууцны хөлс төлөхөд дэмжлэг үзүүлэхээр тусгана.

Мөн ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, аж ахуйн нэгж байгууллагыг дэмжих, Монголын ахмадын байгууллагын статус, санхүүжилтийн талаар хуулийн төсөлд тодорхой тусгана.

### **Гурав. Ахмад настны тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл батлагдсанаар үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагаврын талаар**

Ахмад настны тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл батлагдсанаар ахмад настанд төрөөс үзүүлэх дэмжлэг үйлчилгээнд хамрагдах хүний тоо өсөж 40.0 гаруй тэрбум төгрөгийн нэмэлт хөрөнгө шаардагдана.

Ахмад настны тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн нэмж шаардагдах хөрөнгөний 80 гаруй хувь ахмад настны хөгжлийн болон эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх, сэргээн засах зэрэг ахмад настны эрүүл мэнд, нийгмийн оролцоог дэмжихэд чиглэсэн иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагаар гэрээлэн гүйцэтгэх болон хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээнд зарцуулагдана.

Ингэснээр ахмад настны урт хугацааны асаргаа үйлчилгээ, эрүүл насжилтыг дэмжиж, эрүүл мэнд, нийгмийн оролцоо сайжирч улмаар эмнэлэгт хэвтэх, эм худалдан авах зэрэг эрүүл мэндийн даатгалын үйлчилгээний зардал аажмаар буурах эерэг нөлөөтэй юм. Мөн иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагаар гэрээлэн гүйцэтгүүлэх үйлчилгээг дэмжсэнээр ахмад настны болон мэргэжлийн байгууллагуудын ажлын байрыг нэмэгдүүлж, эдийн засагт сайнаар нөлөөлнө.

Хуулийн төсөл батлагдсанаар ахмад настанд үзүүлэх үйлчилгээний хүртээмж, чанар сайжрах; асран хамгаалагч, харгалзан дэмжигчдийн үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн чиг хандлага дээшлэх; ахмад настны хөдөлмөр эрхлэлт, нийгмийн идэвх нэмэгдэх, ахмад настны асран хамгаалагч, харгалзан дэмжигчид нь

богино болон урт хугацаагаар чөлөөлөгдөж амрах, ажил хөдөлмөр эрхлэх боломжтой болох зэргээр нийгмийн хөгжилд эерэг нөлөө үзүүлнэ.

**Дөрөв. Ахмад настны тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл батлагдсантай холбогдуулан нэмэлт, өөрчлөлт орох хуулиуд**

Хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, конвенц, бусад хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулна.

Хуулийн төсөлтэй холбогдуулан Нийгмийн халамжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хөдөлмөрийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд нэмэлт оруулах тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Компанийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эрүүгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт оруулах тухай зэрэг холбогдох хуулийн төслийг тус тус боловсруулна.

ХУУЛЬ САНААЧЛАГЧ



## ТАНИЛЦУУЛГА /товч/

"Ахмад настны тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай" хуулийн төслийн тухай

Дэлхийн хүн амд 65 ба түүнээс дээш насны ахмадууд 2022 онд 10 хувийг эзэлж байгаа ба 2030 онд 12 хувь буюу 994 сая, 2050 онд 16 хувь буюу 1.6 тэрбум болж өснө<sup>3</sup>. Монгол Улсын хувьд 60 ба түүнээс дээш насны ахмад настны тоо 2000 онд нийт хүн амын 5.4 хувь, 2010 байдлаар 5.8 хувь, 2021 оны байдлаар 9.7 хувь байгаа бол 2030 онд 11.9 хувь, 2050 он гэхэд 5 хүн тутмын нэг нь 60 ба түүнээс дээш настай болох магадлалтайг Үндэсний статистикийн хорооноос тооцоолжээ. 2022 оны байдлаар Монгол Улсад нийт хүн амын 10.5 хувь буюу 344.6 мянган ахмад настан байна.

Хүн ам зүйн өөрчлөлтийн улмаас нийт хүн амын дунд ахмад настануудын эзлэх хувь хурдацтай өсөж байгаатай уялдуулан насжилтад бэлтгэх, ахмад настанд үзүүлэх урт хугацааны цогц тусламж үйлчилгээний болон ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлогыг сайжруулах зорилгоор Ахмад настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулав.

2017 онд шинэчилсэн найруулгаар батлагдсан Ахмад настны тухай хуульд ахмад настанд зөвлөгөө өгөх, өдрийн үйлчилгээ, явуулын үйлчилгээ болон өдрөөр эмчлэх, асран сувилах үйлчилгээ зэрэг шинэ төрлийн үйлчилгээг бий болгож, иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэхээр тусгасан ч энэ шинэ үйлчилгээний хэрэгжилт тун хангалтгүй байна. Энэ төрлийн үйлчилгээнд тухайлбал 2022 оны байдлаар 2300 хүнд 600.0 сая төгрөг зарцуулж, нийт ахмад настны нэг хүрэхгүй хувийг хамруулж байгаа нь Монгол Улсад ахмад настныг дэмжих, хөгжүүлэх, нийгмийн амьдралд оролцуулах зэрэг үйлчилгээ байхгүйтэй адил байна гэсэн үг юм.

Ахмад настны тухай хуулийн ихэнх заалтын хэрэгжилтийг хангах чиг үүргийг орон нутгийн байгууллагад өгсөн боловч нэгдсэн арга зүй, удирдлага, зохион байгуулалтаар хангах байгууллага болон арга механизм нь тодорхойгүй, орон нутгийн төсөвт хангалттай хөрөнгө тусгагдаагүй зэрэг шалтгаантай байна. Түүнчлэн Ахмад настны тухай хуулийн дагуу үзүүлэх үйлчилгээ, дэмжлэг туслалцаа нь ахмадуудын тодорхой зорилтот бүлэгт бус, нийт ахмадуудын эрэлт хэрэгцээнд үндэслэх шаардлагатай.

Одоогоор манайд ахмад настанд зөвхөн протез, ортопедийн хөнгөлөлт үзүүлэх, амралт рашаан сувиллын хөнгөлөлтийг жилд нэг удаа үзүүлэхээс өөр тэдэнд зориулсан байнгын тогтмол үзүүлдэг төрөл бүрийн сэргээн засалтын болон хөгжил, хамгааллын үйлчилгээ дутагдалтай байна. Иймд ахмад настны цогц тусламж үйлчилгээний тогтолцоог бүрдүүлэх, санхүүжилтийг тодорхой болгох, урт хугацааны тусламж үйлчилгээг хөгжүүлэх шаардлагын үүднээс хуулийн төсөлд тодорхой заалтуудыг тусгасан.

Хүн амын дундаж наслалт тогтмол нэмэгдэж улмаар хөдөлмөрийн насны хүн амд ноогдох ахмад настануудын тоо 2010 онд 10 хүн тутамд 1 байсан бол, 2040 он гэхэд 4 хүн тутамд 1 болохоор байна. Өөрөөр хэлбэл хүн ам насжихын хирээр залуу

<sup>3</sup> <https://www.visualcapitalist.com/cp/charted-the-worlds-aging-population-1950-to-2100/>

ажилчдын эзлэх хувь буурах тул мэдлэг чадвартай, ажил амьдралын туршлагатай ахмад ажилчдын хөдөлмөр эрхлэлтийг зохистой хэлбэрээр дэмжих шаардлага тулгарч байна.

Иймд ахмад настны тогтвортой орлогын эх үүсвэрийг хангах зорилгоор ахмад настнуудыг үргэлжлүүлэн хөдөлмөр эрхлүүлэхийг дэмжих, эдийн засгийн идэвхийг нь хадгалах, ахмад настнууд өөрийн чадавхыг амьдралынхаа туршид бүрэн дүүрэн ашиглах, тэдний мэргэжил, туршлага, ур чадварт түшиглэж залуу үеийг сургах, нөгөө талаар ахмад настан бүх нийтийн үйл хэрэгт идэвхтэй оролцох оролцоог дэмжин ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих олон талт бодлогыг батлан хэрэгжүүлэх зорилгоор Ахмад настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах төсөлд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих заалтуудыг тусгав.

Сүүлийн жилүүдэд гэр бүлийн хүчирхийллийн дуудлагад ахмад настны эсрэг хүчирхийлэл нэмэгдэж байна. 2020 оноос 2022 оны байдлаар Хүчирхийллийн эсрэг үндэсний төвд хандсан ахмад настны эсрэг үйлдэгдэж буй хүчирхийллийг хэлбэрээр нь ангилан үзэхэд эдийн засгийн хүчирхийлэл 36 хувийг эзэлж байна. Иймд ахмад настанд тохиолдож байгаа эдийн засгийн хүчирхийлэл буюу тэтгэвэр, тэтгэмжийг нь зөвшөөрөлгүй зарцуулах, барьцаалж зээл авах, өмч хөрөнгийг нь дур мэдэн зарцуулах, ашиглах зэрэг асуудлын зохицуулах зорилгоор Эрүүгийн болон Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах төслийг боловсруулсан. Мөн Ахмад настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуульд ахмадын байгууллагын статус, санхүүжилтийг тодорхой зааж өгсөн.

Энэ хууль батлагдсанаар ахмад настанд төрөөс үзүүлэх дэмжлэг үйлчилгээнд хамрагдах ахмад настны тоо өсөж 50.0 орчим тэрбум төгрөгийн нэмэлт хөрөнгө шаардагдана. Нийт зардлын 80 гаруй хувь ахмад настны хөгжлийн болон эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх, сэргээн засах зэрэг ахмад настны эрүүл мэнд, нийгмийн оролцоог дэмжихэд чиглэсэн иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагаар гэрээлэн гүйцэтгэх болон хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээнд зарцуулагдана.

Ингэснээр ахмад настны урт хугацааны асаргаа үйлчилгээ, эрүүл насжилтыг дэмжиж, эрүүл мэнд, нийгмийн оролцоо сайжирч улмаар эмнэлэгт хэвтэх, эм худалдан авах зэрэг эрүүл мэндийн даатгалын үйлчилгээний зардал аажмаар буурах эерэг нөлөөтэй юм. Мөн иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагаар гэрээлэн гүйцэтгүүлэх үйлчилгээг дэмжсэнээр ахмад настны болон мэргэжлийн байгууллагуудын ажлын байрыг нэмэгдүүлж, эдийн засагт сайнаар нөлөөлнө.